# БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА ДАВААСАМБУУ ОВОГТОЙ ЖАРГАЛСАЙХАНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | | | |
| 1. | Эрсдэлийн судалгаа, шинжилгээний үр дүнгээс шалгалтанд хамрагдах иргэн, хуулийн этгээдийн сан үүсгэсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 | Шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээдийн санг баяжуулсан байна. | Тайлант хугацаанд CIMS програмын “БДШ-тад хамрагдах иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн сан”-д нийт 63 ААН, байгууллагыг дараах байгууллага, ГЕГ-ын ЗББН-ээс ирүүлсэн хүсэлт, холбогдох эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээний үр дүнг үндэслэн бүртгэж, санг баяжуулсан. Үүнд:<br>▪ АТГ-ын албан бичгийн дагуу 1 ААН;<br>▪ ГЭУХ-ийн 2025.02.18-ны өдрийн 01800/39, 2025.03.11-ний өдрийн 01800/52, 2025.04.17-ны өдрийн 01800/95 тоот, нийт 4 Дотоод зурвасаар нийт 35 ААН, байгууллага;<br>▪ БЦТ-ийн 2025.03.18-ны өдрийн 279 тоот Дотоод зурвасаар нийт 4 ААН; | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ▪ БАУХ-ийн 1 дотоод зурвасаар ирүүлсэн 1 ААН-ийн мэдээлэл судалгааг үндэслэн 1 ААН;<br>▪ Гомдол мэдээллээр 3 ААН;<br>▪ БДШГ-ын дотоод эрсдлийн судалгааны дагуу 19 ААН, байгууллага тус тус бүртгэгдсэн.<br>2025.06.03-ны байдлаар шалгалтад хамруулах иргэн, хуулийн этгээдийн санд нийт 503 ААН, байгууллага бүртгэгдсэн байна.<br>“БДШ-тад хамруулах иргэн, хуулийн этгээдийн сан”-д өмнөх онд оруулсан мэдээллийг 14.3%-иар нэмэгдүүлсэн. | | |
| 2. | Гадаад худалдаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагад эрсдэлийн удирдлагад суурилсан бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийх | Шалгалтын тоо, мөнгөн дүнгээр | - | Бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийсэн байна. | Тайлант хугацаанд 2024 оны шалгалтын удирдамжаар 5 ААН, байгууллага, 2025 оны удирдамжаар 70, нийт 75 ААН, байгууллагыг бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамруулснаас 2025.06.05-ны байдлаар нийт 58 ААН, байгууллагад хийсэн шалгалт бүрэн дуусч шалгалтын үр дүнгээр 41 ААН, байгууллагад зөрчил илэрч, 17 ААН, байгууллагад зөрчил илрээгүй. Тайлант хугацаанд хийгдсэн шалгалтын үр дүнгээр илэрсэн нийт 41 ААН, байгууллагад холбогдох зөрчлийг дараах байдлаар шалгаж шийдвэрлэлээ. Үүнд:<br>▪ 3 ААН, байгууллагад холбогдох 19.5 тэрбум төгрөгийн дүн, 3.0 тэрбум хохирлын дүн бүхий зөрчил нь | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эрүүгийн хуулийн 18.3 дахь зүйлийн дагуу их хэмжээний татвараас зайлсхийх гэмт хэргийн шинжтэй зөрчил байсан тул Нийслэлийн прокурорын газрын хяналтан дор харьяаллын дагуу Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн;<br>▪ 38 ААН, байгууллагад холбогдох 9.5 тэрбум төгрөгийн дүн бүхий зөрчлийг Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу Захиргааны журмаар шалган шийдвэрлэж, нийт 2.3 тэрбум төгрөгийн нөхөн татвар, торгуулийг оногдуулсан.<br>Шалгалтын үр дүнгээр нийт 2 тэрбум төгрөг (өмнөх он болон энэ оны шалгалтын үр дүн)-ийг улсын төсөвт төвлөрүүлсэн.<br>Тайлант хугацаанд хийж дууссан шалгалтын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 65.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. | | |
| 3. | Төрийн болон хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Төрийн болон хууль, хяналтын байгууллагатай хамтран ажилласан байна. | Тайлант хугацаанд Нийслэлийн прокурорын газар, Эрүүгийн цагдаагийн алба, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Захиргааны хэргийн анхан, дунд, хяналтын шатны шүүх болон бусад хууль хяналтын байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллалаа: | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ▪ ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргаж, гомдлыг давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн;<br>▪ ХХК-ийн нэхэмжлэлтэй Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралд оролцсон;<br>▪ БДШ-ын үр дүнгээр захиргааны журмаар шалган шийдвэрлэсэн нийт 41 зөрчлийн хэргийн материалыг НПГ-аар хуулийн хугацаанд нь хянуулж ажилласан. Тайлант хугацаанд захиргааны журмаар шалган шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 60 орчим хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>▪ БДШ-ын үр дүнгээр илэрсэн татвараас зайлсхийх гэмт хэргийн шинжтэй 3 зөрчлийг ЭХ-ийн 18.3 дахь зүйлийн дагуу Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн;<br>▪ Шалгалтын үр дүнгээр нөхөн ногдуулсан татвар, торгуулийг барагдуулах чиглэлээр ХХК, ХХК зэрэг 2 ААН, байгууллагад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох асуудлаар Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2 удаа хандаж, шийтгэлийн хуудсыг албадан гүйцэтгүүлэх хуудас гаргуулж, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн;<br>▪ 2025.04.17-ны өдөр Прокурорын ерөнхий газар, Нийслэлийн прокурорын газраас ГЕГ болон УБГГ, УХШИГГ-ын ЭБАТ-нуудад зориулан зохион байгуулсан “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” сургалтын бэлтгэл ажлыг хангаж, хамтран ажилласан:<br>▪ ЭЦГ-аас ирүүлсэн ХХК болон ХХК, ХХК-ийн шалгалтын үр дүнтэй холбоотойгоор асуудлыг судалж, 2025.05.09 болон 2025.06.02-ны өдрийн 01-6/1962, 01-6/2327 тоот албан тоотоор хариу хүргүүлж хамтран ажилласан;<br>▪ БДШ-ын үр дүнгээр Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн нийт 15 ААН, байгууллагад холбогдох татвараас зайлсхийх гэмт хэргийн шинжтэй 83.1 тэрбум төгрөгийн зөрчлийн дүн бүхий зөрчлийг шалган шийдвэрлүүлэх чиглэлээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байна;<br>▪ АТГ-тай хамтран 1 ААН, байгууллагад шалгалт хийж, ажиллаж байна;<br>▪ Өмнөх оны өр төлбөрийг барагдуулах чиглэлээр НШШГГ болон Банкны өр барагдуулах газартай хамтран 5 ААН, байгууллагын 5.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр хамтран ажиллаж, 52.5 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан;<br>▪ Нийслэлийн прокурорын газрын шийтгэлийн биелэлтийн шалгалт, Үндэсний аудитын газрын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийх аудит болон нийслэл дэх төрийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитад хамрагдаж, холбогдох баримт, мэдээ тайлан, тайлбарыг хугацаанд нь гарган хүргүүлж, хамтран ажилласан. | | |
| 4. | Бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтыг зохион байгуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтыг зохион байгуулж ажилласан байна. | Тайлант хугацаанд дараах шуурхай шалгалтыг зохион байгуулж ажилласан. Үүнд:<br>▪ АТГ-аас ирүүлсэн 2025.03.17-ны өдрийн 06/5194 тоот албан бичгийн дагуу<br>ХХК-д бүрдүүлэлтийн дараах шуурхай шалгалтыг зохион байгуулж, шалгалтын явцыг | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тус байгууллагад тухай бүр танилцуулж ажилласан.<br>▪ Мөн ХХК-иас ирүүлсэн 2025.03.10-ны өдрийн албан хүсэлтийн дагуу ХХК, ХХК, ХХК, ХХК-ийн импортын цэцэгтэй холбоотой асуудлыг 2502000194 тоот зөрчлийн хэрэг нээж, Нийслэлийн прокурорын хяналтан дор шалган шийдвэрлэсэн;<br>▪ Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус байдлаар нийт 40 ААН, байгууллагыг шалгалтад хамруулсан. | | |
| 5. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж ажилласан байна. | Тайлант хугацаанд нэгжийн чиг үүрэгтэй хамааралтай дараах бодлогын баримт бичигтэй танилцаж, хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох саналыг ХНХ-т Дотоод зурвасаар хүргүүлж ажилласан. Үүнд:<br>▪ Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын багц баримт бичиг.<br>Мөн дээрх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхтэй холбоотой 2 удаагийн санал асуулгад нэгжийн хамт олныг бүрэн хамруулсан. | 2025.01.01-2025.06.05 | 100 |
| 6. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | | - | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх | Тайлант хугацаанд дараах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнд:<br>▪ Гаалийн тухай хууль; | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | ▪ Зөрчлийн тухай хууль;<br>▪ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;<br>▪ Эрүүгийн хууль;<br>▪ Захиргааны ерөнхий хууль;<br>▪ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;<br>▪ Гаалийн хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой журам. | | |
| 7. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж ажилласан байна. | Тайлант хугацаанд Захиргаа удирдлагын СЕРП програмаар ГЕГ-ын ЗББН-ийн дарга нараас нийт 14 үүрэг даалгавар ирж, үүрэг даалгаврыг цаг тухайд нь бүрэн биелүүлж, гүйцэтгэлийг СЕРП програмд оруулж ажилласан.<br>Тайлант хугацаанд ирсэн нийт үүрэг даалгаврын 10 буюу 71.4% нь ХШҮДАГ; 3 буюу 21.4% нь ЗУГ, 1 буюу 7.2% ТОГ-аас тус тус ирсэн байна.<br><br>Мөн гаалийн байгууллагын онлайн шуурхай хурлаас тухай бүр өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж ажилласан. | 2025.01.01-2025.06.05 | 100 |
| 8. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, хувиар | - | Ажлын цагийг бүрэн ашигласан байна. | 2025.01.01-2025.05.31-ний хооронд нийт 105 хүн өдөр буюу 840 хүн цаг ажиллахаас 105 хүн өдөр буюу 840 хүн цаг ажиллаж, ажлын цагийн ашиглалт 100%-тай байна. | 2025.01.01-2025.06.05 | 100 |
| 9. | ЗББНДБ-ын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллах, цаг үеийн шинжтэй | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | ЗББНДБ-ын үйл ажиллагааны | Тайлант хугацаанд ЗББНДБ-ын үйл ажиллагааны уялдааг хангаж ажиллах, цаг үеийн шинжтэй арга | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээг тухай бүр гүйцэтгэж ажиллах. | | | уялдаа холбоог хангаж ажилласан байна. | хэмжээг авч ажиллах чиглэлээр ГЭУХ, ТОГ, БАУХ, ХХ, СДШХ-тэй дараах чиглэлээр хамтран ажилласан. Үүнд:<br>▪ Төсвийн орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх;<br>▪ Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;<br>▪ 507 горимын хэрэгжилтийн байдалд дүгнэлт гаргах;<br>▪ ЭЗИО-ийн итгэмжлэл олгох (нийт 3 ААН, байгууллагад итгэмжлэл олгох үйл ажиллагаанд хамтран ажилласан);<br>▪ Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх. | | |
| 10. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ажилласан байна. | ГЕГ-ын даргын 2022.12.14-ны өдрийн А/342 тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-ыг танилцуулж албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх, эрсдлийн талаарх танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан.<br>- Гаалийн байгуулагын эрсдлийн судалгааг хийж "Эрсдлийг бууруулах арга хэмжээ" дүн шинжилгээний /23 хуудас/ баримттай танилцаж цаашид дотоод эрсдлийг бууруулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>- Журмын хэрэгжилтийн хүрээнд 2024 онд 9 дотоод эрсдэл тооцож бууруулах арга хэмжээ авч, мариц | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дундажаар үнэлсэн, мөн үнэлгээ бууруулсан ч үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажилд тулгуурлан 2025 онд гадаад хүчин зүйлийн нөлөөтэй 2 ажил, дотоод ажил 2 төлөвлөж бууруулан ажиллаж бааз үүсгэсэн.<br>- Дахин эрсдэлийн давтамж, үр дагаварын үржвэрээр эрсдэлийн матрицаа гаргаж, эрсдэлийн түвшинг тодорхойлоод журмын 5.8-д заасан итгэлцүүрийн үржвэрээр үржүүлж эрсдэлийн оноог гаргасан. Дахин үнэлж гаргасан эрсдэлийн оноог анх үнэлсэн үзүүлэлттэй харьцуулахад 3 ажилыг 25-33.3%-аар буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:<br>Дахин үнэлж гаргасан эрсдэлийн оноог анх үнэлсэн үзүүлэлттэй харьцуулахад:<br>1. БДШ-ын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл (ААН -ээс санхүүгийн бичиг баримт өгөхгүй байх, эсвэл ня/бо бүртгэл хөтлөхгүй байх эрсдэл 33.3%,<br>2. БДШ-ын өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл (Шалгалтын явцад хэрэглэгдэх зөөврийн компьютер ГУБ нарт хүрэлцдэггүй эрсдэл бууруулаагүй. Санхүүгийн чадвараас хамаарч сүүлийн хагас жилд СХОХ-ээс нийлүүлнэ.<br>3.Албан хаагчдын ажлын цаг ашиглалттай холбоотой эрсдэл 25%,<br>4.Нэгжийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлтэй холбоотой эрсдэл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | (нөхөн төлөх татвар, торгууль Эрүүгийн хуулийн 2.5.4.1 -д заасан хэмжээнээс дээш бол холбогдох байгууллагад шилжүүлэх) эрсдэл 25 %-аар тус тус буурсан байна. | | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 11. | Нөхөн төлбөрийн авлагыг барагдуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Нөхөн төлбөрийн авлага буурсан байна. | Өмнөх онуудад БДШ-ын үр дүнгээр тавигдсан өр төлбөрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2025 оны 03 сард тусгайлан төлөвлөгөөг баталж, тус төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Өмнөх онуудад БДШ-аар нөхөн ногдуулсан төлбөрийн үлдэгдэл 8,8 тэрбум төгрөгөөс тайлант хугацаанд 117,0 сая төгрөгийг барагдуулсан.<br>Тухайлбал,<br>▪ Хаяг байршил тодорхойгүй 1 иргэн, 6 ААН-ийн 87.4 сая төгрөгөөс 1 ААН ( ХХК)-ийн 3.4 сая төгрөгийг бүрэн барагдуулсан;<br>▪ Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Банкны өр барагдуулах газарт шилжүүлсэн 5 ААН-ийн 5.2 тэрбум төгрөгөөс 2 ААН ( ХК, ) ХХК)-ийн 52.5 сая төгрөгийг барагдуулсан;<br>▪ Графикаар төлөгдөж байгаа өр төлбөр болон шүүхийн шатанд байгаа 11 ААН (: ХХК, ХХК)-ийн 3.5 тэрбум төгрөгөөс 2 ААН-ийн 61.0 | 2025.01.01-2025.06.05 | 86 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сая төгрөгийг бүрэн барагдуулсан;<br>Мөн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:<br>▪ НШШГ, БӨБАлбанд 2025.05.12-нд ’ ’ ХХК -д гүйцэтгэх тогтоол гаргуулахаар ЗШХАШШүүхэд шилжүүлж, гүйцэтгэх тогтоолыг БӨБАлбанд шилжүүлэхэд хариуцсан ГУБ-д чиглэл өгч хамтран ажилласан;<br>▪ Авлага барагдуулах талаар НШШГ-тай 5 удаагийн биечилсэн уулзалт, 3 удаа албан тоот;<br>▪ Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 6 удаа шүүх хандсан;<br>▪ Өмнөх оны өр авлагатай 1 иргэн, 2 ААН-ийн авлагыг барагдуулах талаар 2025.03.27-ны өдрийн 01-6/29 дотоод зурвасаар хандаж ажилласан. | | |
| 12. | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу биет бараанд гаалийн нөхөн бүрдүүлэлт хийх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | - | Биет бараанд нөхөн бүрдүүлэлт хийсэн байна. | Тайлант хугацаанд 12 иргэн, 5 ААН, байгууллагаас ирүүлсэн биет бараанд нөхөн бүрдүүлэлт хийх хүсэлтийн дагуу нийт 22 гаалийн мэдүүлгээр 56.5 мянган ам.доллар буюу 196.7 сая төгрөгийн статистик үнийн дүн бүхий бараанд гаалийн нөхөн бүрдүүлэлт хийж, 11.5 сая | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгийн гааль, 20.7 сая төгрөгийн НӨАТ, нийт 32.2 сая төгрөгийн татвар, 14 сая төгрөгийн торгууль, нийт 46.2 сая төгрөгийг ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн. | | |
| **Зорилт 4. Соён гэгээрүүлэх** | | | | | | | |
| 13. | Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлээр сургалт зохион байгуулж, ГУАБ, ГУБ нарыг мэргэшүүлэх | Хэрэгжилт, хувиар | 100 | ГУАБ, ГУБ нарт сургалт зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд Сургалтын төвөөс зохион байгуулсан дараах сургалтад тус төвтэй хамтран ажиллаж, сургалтад хамрагдсан ГУАБ, ГУБ нарын БДШ-ын мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр тус нэгжээс холбогдох сургалтыг зохион байгуулах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:<br>▪ 2025 оны 02 дугаар сард зохион байгуулсан Хорио цээрийн ГУБ нарт зориулсан сургалт;<br>▪ 2025.04.17-ны өдөр зохион байгуулсан “Бичиг баримтын бүрдүүлэлтийн ГУБ нарыг мэргэшүүлэх сургалт”;<br>▪ 2025.05.30-ны өдөр зохион байгуулсан ЧХОУНБГГ-ын Хорио цээрийн асуудал хариуцсан ГУБ нарыг мэргэшүүлэх сургалт. | 2025.01.01-2025.06.05 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 | Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна. | ▪ Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллан холбогдох санал боловсруулж, ХХ-ээр дамжуулан Сангийн яаманд хүргүүлсэн;<br>▪ ЗУГ-аас өгсөн үүрэг даалгаврын дагуу гаалийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөл болон гаалийн байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлж ажилласан;<br>▪ БДШ-ын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр УБГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-аас Google Form-оор санал асуулга авч, үр дүнг нэгтгэсэн;<br>▪ "Татварын ерөнхий газар болон Гаалийн ерөнхий газар 2025 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-нд хамтарсан шалгалт хийх талаар санал өгч ажилласан. Тус төлөвлөгөө хоёр байгууллагын дарга нарын хамтарсан 2025.04.17-ны өдрийн А/62, А/154 тоот тушаалаар батлагдсан;<br>▪ Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсэгт 2025.05.06-ны өдрийн 01-6/61 тоот зурвасаар ДХБ-ын "Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийн тайлан"-г бэлтгэж хүргүүлсэн; | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ▪ Сар бүрийн эхний 7 хоногт Сангийн сайдын 18 дугаар тушаалын биелэлтийн тайланг гаргаж, ТОГ-т хүргүүлж байгаа;<br>▪ Сар, 7 хоног бүрийн нэгжийн тайлан, төлөвлөгөө, биелэлтийг СЕРП-д оруулж ажиллаж байна;<br>▪ "Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, үр дүнг тухай бүр ТОГ-т хүргүүлж байна. Энэ төлөвлөгөөний дагуу нийт 85 ААН, байгууллагыг хамарсан 3 чиглэл (Хүнсний ногоо, барилгын хавтан, алт үнэт эдлэл)-ээр эрсдэлийн судалгааг хийж, үр дүнг үндэслэн БДШ-ыг зохион байгуулж ажиллаж байна;<br>▪ Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтын брошурын эхийг бэлтгэж, батлуулсан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах | | 5 | Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдсан. | ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төв дээр зохион байгуулагдсан Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт (А3)-ад хамрагдаж, шалгалтад 35 оноо авсан. Үүнд:Удирдлагын академиас зохион байгуулсан "Стратеги | 2025.01.01-2025.06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хамрагдсан сургалтын тоо | | | төлөвлөгөө хийхэд анхаарах асуудал”;<br>▪ Нийслэлийн прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал”. | | |
| 2. | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Сургалтад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна. | Тайлант хугацаанд холбогдох хууль журмыг бие даан судалж, мэдлэгээ дээшлүүлж ажилласан. | 2025.01.01-2025.06.05 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЖАРГАЛСАЙХАН | ................................ /Д.ЖАРГАЛСАЙХАН/ | 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ БҮРДҮҮЛЭЛТИЙН ДАРААХ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА ДАВААСАМБУУ ОВОГТОЙ ЖАРГАЛСАЙХАНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 64,3 |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах | | 13,5 |
| 2. | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | | 13,5 |
| **Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 13,5 |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 13 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 13 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 13 |
| 4. | Манлайлах | 12 |
| 5. | Багаар ажиллах | 13 |
| 6. | Харилцаа | 14 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 13 |

## 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 64,3 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13,5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 13 |

| | | |
|---|---|---|
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | — |
| **Нийт оноо=**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 90,8 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч:**

Гаалийн ерөнхий газрын дарга ........................ (Р.Отгонжаргал)

2025.06.25 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын дарга ........................ (Д.Жаргалсайхан)

2025.06.10 (огноо)